

ИСПАНИ ХЭЛТ ЗОХИОЛЧДЫН БҮТЭЭЛИЙГ МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН ТУРШЛАГААС

Б.Пүрэвсүрэн¹⁰

Товч утга: Испанийн болон Америк тивийн испани хэлтэн ард түмний утга зохиолоос монгол хэлнээ орчуулсан бүтээлийг бүртгэх ажлын эхлэлийг нэгтгэсэн үр дүнг өгүүлсэн болно.

Түлхүүр үг: Испанийн болон испани хэлтнүүдийн уран зохиол, уран зохиолын орчуулга

Эртний Грек, Ромын соёл иргэншлийн утга зохиолын өвийг уламжлан хадгалж өнөө цагт залгуулсан улс үндэстний нэг бол Пиренейн хойгийн испаничууд юм. Үүний зэрэгцээ дэлхийн бөмбөрцгийн нөгөө талд орших испани хэлт ард түмний уран зохиол ч өнгөрсөн зууны дунд үеэс эхлэн монгол уншигчдын хүртээл болсоор иржээ. Испани хэлт 20 гаруй улс үндэстний соёл, оюун санааны үнэт зүйл, нийгмийн олон талт үйл явдлыг уран зохиолоор дамжуулан ойлгоход орчуулгын бүтээл үнэ цэнтэй байр эзлэдэг билээ. Агуу их Сервантесийн “Кихот ноён”, их яруу найрагч Федерико Гарсиа Лоркагийн “Хонины булаг” тэргүүтэй уран бүтээлийг сэтгэлийн дуудлагаараа цөөнгүйг орос хэлнээс дам орчуулан монгол уншигчдын хүртээл болгосон бол орчуулагч Б. Пүрэвсүрэн 1974 онд Педро Антонио дэ Аларконы “Гурвалжин малгайт” зэрэг зохиолыг испани хэлнээс орчуулсан байх жишээтэй.

2006 онд Дэлхийн яруу найрагчдын 26 дугаар их хурал Монгол Улсад чуулсанд зориулан Монголын Соёл, Яруу найргийн Академиас испани хэлтэн үндэстнүүдийн яруу найргийн дээжээс хураан цуглуулж “Дэлхийн шилдэг яруу найраг” цувралын VI ботийг испани болон орос хэлнээс орчуулсан бүтээлээс “Испани аялгуу буюу испани хэлтний яруу найраг” (Poetas en español) нэрээр хэвлүүлэх ажлыг МУ-ын СГЗ Г.Мэнд-Ооёо, Хэлбичгийн ухааны доктор Б.Магсаржав нар эрхлэн эмхтгэж “Испанийн яруу найраг”, “Латин Америкийн испани хэлтэн үндэстнүүдийн яруу найраг” гэсэн хоёр бүлэгтэй хэвлүүлжээ.

Уг эмхтгэлд Б.Явуухулан, М.Цэдэндорж, Ж.Лхагва, С.Лочин, Б.Энэбиш, Л.Хуушаан, Б.Магсаржав, Д.Даваа, Ч.Чимид, Ц.Дамдинсүрэн, Г.Лувсанцэрэн нарын яруу найрагч, зохиолч, дуун хөрвүүлэгч нарын орос хэлнээс дам орчуулсан бүтээл, мөн испани хэлнээс Д.Даваашарав, Б.Батболд, Б.Пүрэвсүрэн, Г.Гэндэндарам, Н.Нямдорж нарын орчуулга оржээ. Аман зохиол, яруу найргийн бүтээл сэдвийн хувьд байгалийн үзэсгэлэн, хайр сэтгэл, ард түмний нөхөрлөл, энх тайван, эрх чөлөө гэсэн нийтлэг сэдвийн зэрэгцээ социалист нийгмийн иргэдийн зол жаргалтай амьдрал, эрдэм боловсролыг дээдлэх үзлийг тунхагласан зохиол дийлэнх нь байна.

¹⁰ МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхимийн ахлах багш

Пабло Нерудагийн нэгэнтээ “Атлантын далай болон Николас Гильений шүлгээр хүрээлэгдсэн нэг арлыг Куба гэнэ” хэмээн тодорхойлон хэлсэнчлэн кубын баатарлаг ард түмний утга зохиолоос орчуулах ажил хувьсгал ялсан өдрөөс манайд эхэлсэн бөгөөд Б.Чулуун Куба орны тухай яруу найраг, сурвалжлага, тэмдэглэл 20 гаруйг орчуулан сонин, сэтгүүлд нийтэлж, Хосе Мартийн зохиол бүтээл “*Гэрийн хорио*” (1980), “*Алтан үе*” (1982), “*Зүрхний хайрт хүү минь*” (1988) зэргийг орчуулсан бөгөөд 2000 онд “Оюуны ундраа” эмхтгэлдээ “Эдүгээ миний мэдэх 20 орчим ном, сонин хэвлэлийн олон зуун материал, түүний дотор Кубын хувьсгалын удирдагчдын хэлсэн үг, өгүүлэл, тууж, өгүүлэг, яруу найраг, сурвалжлага монгол хэлээр нийтлэгдсэн байна” хэмээжээ.

Дурдсан зохиолуудыг бүртгэж үзвэл: Ж.Лхагва “*Янагийн өвөр хүүгийн өлгий*” Хосе Мартийн яруу найргийн түүвэр (1967), М.Цэдэндорж, Б.Батболд нар “*Кубын дуу*” Николас Гильений яруу найргийн түүвэр (1982), Г.Гэндэндарам “*Өгүүллэгийн түүвэр*” Онелио Хорхе Кардос (1982), Б.Пүрэвсүрэн Куба зохиолчдын бүтээлээс “*Саарал дэглийн сүйрэл*” (1972), Д. Даваашарав “*Пене ба бусад өгүүллэг*” гэх мэт орчуулсан байх бөгөөд Хосе Солер Пуйн “*Вертильон 166*” роман, Фидель Кастрогийн “*Түүх намайг цагаатгана*” (1978), Суут хүмүүсийн амьдралын цувралаар “*Эрнесто Че Гевара*” зэрэг бүтээлийг мөн монголчилжээ.

Колумбын бичгийн их хүн, Нобелийн шагналт зохиолч Габриель Гарсия Маркесийн 1967 онд бичсэн “*Зуун жилийн ганцаардал*” зохиолыг Г.Аким, 1961 онд бичсэн “*El coronel no tiene quien le escriba*” зохиолыг Н.Энхбаяр “*Мартагдсан хурандаа*” хэмээн гарчиглаж, харин О.Чинбаяр 2008 онд “*Хурандаад хэн ч бичихгүй*” хэмээн орчуулжээ.

Б.Нямдорж Маркесийн 2004 оны “*Memoria de mis putas tristes*” зохиолыг “*Гунигт яхнуудаа дурсахуй*” хэмээн орчуулж 2013 онд хэвлүүлж, “*La increíble y triste historia de la cándida Eréndira y de su abuela desalmada*” зохиолыг “*Сайхан сэтгэлтэй Эрэндира, түүний хатуу харгис эмэг ээж хоёрын байж болошгүй мөртлөө эмгэнэлтэй түүх*” туужийг орчуулан хэвлүүлээд байна.

Мөн Б.Нарантуяа “*Хөрмөг*”, Л.Алтангэрэл “*Дурлал хийгээд бусад чөтгөрүүдийн тухай*”, Г.Аюурзана “*Бальтасарын гайхамшигт үдэш*”, Э.Ганболд “*Алдагдсан цагийн тэнгис*” (2007), Хулио Кортасарын “*Эзлэгдсэн байшин*”, “*Тоглоом дууслаа*” шилмэл өгүүллийн түүвэр, Г.Аюурзана Хорхе Луис Борхэсийн “*Зүүдний ном*” сонгомол эссэ, өгүүллийн түүвэр “*Хоёр хаан, Хоёр Хонгил*” болон Испанийн яруу найрагч Хусто Хорхе Падроны “*Тамын тойрог*” зэрэг реализм, постмодернизм, сюрреализмын чиглэлийн шилдэг зохиол, яруу найргийн номыг испани хэлнээс монгол хэлнээ орчуулагч Б.Нямдорж, Б.Пүрэвсүрэн нар орчуулжээ.

Энд дурдсан орчуулгын бүтээлийн жагсаалтыг бүрэн гүйцэд болгож испани хэлнээс орчуулсан үе үеийн орчуулагчдын бүтээлийг бүртгэх ажлыг үргэлжлүүлэн хийх шаардлагатайг дурдъя.

Номзүй

1. Б.Чулуун, “Оюуны ундраа”, 2000.
2. Г.Мэнд-Ооёо, Б.Магсаржав нар “Испани аялгуу буюу испани хэлтний яруу найраг”, 2006.
3. Цахим эх сурвалжууд